

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2025/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulzii.t@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70503020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
Сайншанд	Ахлах аудитор: О.Нарангарав Утас: 70523020 Цахим хаяг: narangerav.o@audit.gov.mn
2025 он	Аудитор: Г.Мөнх-Оргил Утас: 70523020 Цахим хаяг: Munkhorgilg.@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

	ТАЙЛАНГИЙН АГУУЛГА
<u>Тайланг бэлтгэсэн:</u>	
Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгийн тайлбар3
Дарга, тэргүүлэх аудитор:	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй4
Т.Ган-Өлзий	Ерөнхий мэдээлэл 5
Аудитын менежер:	БҮЛЭГ 1: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ 6
У.Оюунтүлхүүр	БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ.....11
Ахлах аудитор:	БҮЛЭГ 3: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ13
О.Нарангарав	БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ17
Аудитор:	ДҮГНЭЛТ:19
Г.Мөнх-Оргил	
2025 оны 04 сарын 18	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70522734, 70503020 дугаарын утас, dornogovi@audit.gov.mn хаягаар харилцана уу.	
ХАЯГ:Дорноговь аймаг, Сайншанд сум, Төрийн өмчийн 3 дугаар байр.	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

<i>ИТХ</i>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<i>УИХ</i>	Улсын Их Хурал
<i>ТЕЗ</i>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<i>ОНХО</i>	Орон нутгийн хөрөнгө оруулалт
<i>ТЗШ</i>	Тусгай зориулалтын шилжүүлэг
<i>ОНХС</i>	Орон нутгийн хөгжлийн сан
<i>ОНЕО</i>	Орон нутгийн ерөнхий орлого
<i>СХС</i>	Сум хөгжүүлэх сан
<i>НСС</i>	Нөхөн сэргээлтийн сан
<i>ОН</i>	Орон нутаг
<i>ЗДТГ</i>	Засаг даргын тамгын газар
<i>ЗАА</i>	Захирагчийн ажлын алба
<i>ЗГНХ</i>	Засгийн газрын нэмэлт хөрөнгө
<i>ЗДНХ</i>	Засаг даргын нөөц хөрөнгө
<i>ОНХНС</i>	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
<i>ОНӨГ</i>	Орон нутгийн өмчийн газар
<i>ЗАА</i>	Захирагчийн ажлын алба
<i>БОАЖГ</i>	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
<i>МУ</i>	Монгол Улс
<i>СТА</i>	Санхүүгийн тайлангийн аудит
<i>АТБӨЯХАТ</i>	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
<i>СХАА</i>	Санхүүгийн хяналт, аудитын алба
<i>НҮГ</i>	Нийтлэг үйлчилгээний газар
<i>НТБ</i>	Насан туршийн боловсрол

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд, тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн гүйцэтгэв.

Аудитын зорилт

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалган, дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан, дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт
- Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл
- Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл

Аудитын хамрах хүрээ

Аудитад улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого байгууллага, аж ахуйн нэгж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалыг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд MNS 6817-5:2020 санхүүгийн аудитын зарчим, арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга тодруулга авах, тайлан бусад баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий хянан удирдаж, аудитын менежер У.Оюунтүлхүүр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор О.Нарангарав, аудитор Г.Мөнх-Оргил нар гүйцэтгэв.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг 2025 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлүүлж, тайланг 04 дүгээр сарын 18-ны өдөр дуусган, Үндэсний аудитын газар, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүллээ.

Ерөнхий мэдээлэл:

Сангийн яамнаас Дорноговь аймгийн 2024 оны суурь орлогыг 76,112.3 сая төгрөг, суурь зарлагыг 45,008.4 сая төгрөгөөр хянаж, улсын төсөвт 9,331.2 сая төгрөг төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалтын зардалд 21,772.7 сая төгрөгийг зарцуулахаар, тэнцлийг 31,103.9 сая төгрөг байхаар баталсан байна.

Төсвийн тодотголоор суурь орлогыг 85,575.1 сая төгрөг, суурь зарлагыг 46,329.0 сая төгрөгөөр хянаж, улсын төсөвт 11,773.8 сая төгрөг төвлөрүүлэхээр, орон нутгийн хөрөнгө оруулалтын зардалд 27,472.3 сая төгрөгийг зарцуулахаар, тэнцлийг 39,246.1 сая төгрөг байхаар төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 15/08 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “2024 оны орон нутгийн төсөв баталсан” тогтоолоор орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 133,144.5 сая, төсвийн ерөнхий харилцах дансны оны эхний үлдэгдлээс 250.0 сая, **нийт санхүүжилтийг 133,394.5 сая төгрөгөөр**, урсгал зардлыг 76,672.7 сая, аймгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг 9,331.2 сая, хөрөнгө оруулалтын зардлыг 47,390.6 сая, **нийт зарлагыг 133,394.5 сая төгрөгөөр** тус тус баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 19/01 дүгээр тогтоол болон сумдын ИТХ-ын 2024 оны “2024 оны орон нутгийн төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах” тогтоолоор орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 147,524.9 сая, төсвийн ерөнхий харилцах дансны оны эхний үлдэгдлээс 351.4 сая, **нийт санхүүжилтийг 147,876.3 сая төгрөгөөр**, урсгал зардлыг 82,702.2 сая, аймгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг 11,773.8 сая, хөрөнгө оруулалтын зардлыг 53,400.2 сая, **нийт зарлагыг 147,876.3 сая төгрөгөөр** буюу орлого, зарлагыг 14,481.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, тодотгож баталсан байна.

Тайлант хугацаанд аймаг, сумдын төсөвт 1 удаа тодотгол, жилийн эцэст 2 удаа зохицуулалт хийсэн ба орон нутгийн төсвийн суурь орлогын 96.7 хувийг татварын орлогоор, 3.3 хувийг татварын бус орлогоор бүрдүүлэхээр баталсан байна.

Аймгийн 2024 оны төсвийн нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 180,270.7 сая төгрөгөөр баталж, 15,925.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 196,196.5 сая төгрөг болгож тодотгон, төсвийн зохицуулалтыг хийж баталсан байна.

Аймгийн төсөвт хийгдсэн тодотгол болон төсвийн зохицуулалтаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөнд дараах өөрчлөлтүүдийг хийсэн байна.

Үүнд: ОН-ийн төсвийн санхүүжилтийг 14,380.3 сая, ОНХНС-аас аймгийн төсөвт олгох орлогын шилжүүлгийг 1,409.8 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогын санхүүжилтийг 1.0 сая, тусгай сангуудын орлогыг 17,496.3 сая, урьд оны үлдэгдлийн санхүүжилтийг 118.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

БҮЛЭГ 1: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1.1. Дорноговь аймгийн 2024 оны төсвийн суурь орлогыг МУ-ын Төсвийн тухай хуулийн 57, 58 дугаар зүйлийн 58.2-т заасан нөхцөл, чиг үүрэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", аймгийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон холбогдох хууль тогтоомжийг үндэслэн 43,455.8 сая төгрөгийн төсвийн санал боловсруулж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

УИХ-аас 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан МУ-ын 2024 оны Төсвийн тухай хуулиар аймгийн 2024-ны орон нутгийн төсвийн суурь орлогыг 76,112.3 сая төгрөгөөр буюу төсвийн саналаас 32,656.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Сангийн яамнаас хянаж ирүүлсэн суурь орлогыг аймаг болон сумдын ИТХ-ын 2023 оны "2024 оны төсөв батлах тухай" тогтоолуудаар нийт 133,144.5 сая төгрөгөөр, үүнээс татварын орлогыг 126,878.9 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 6,265.5 сая төгрөгөөр буюу суурь орлогыг нийт 57,032.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Орон нутгийн төсвийн суурь орлого - Анхны төсөв

Хүснэгт №1 /сая төгрөг/

Орлогын төрөл	2023 онд хүргүүлсэн төсвийн санал	Сангийн яамны хянасан орлого	ИТХ-аар баталсан орлого			Нэмэгдүүлсэн дүн
			Аймгийн дүн	Сумын дүн	Нийт дүн	
Татварын орлого	41,971.8	73,965.7	62,079.2	64,799.8	126,879.0	52,913.3
Татварын бус орлого	1,484.0	2,146.6	1,611.3	4,654.2	6,265.5	4,118.9
ДҮН	43,455.8	76,112.3	63,690.5	69,454.0	133,144.5	57,032.2

УИХ-ын 2024 оны 08 дүгээр сарын 30-ны өдрийн 2024 оны Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг 9,462.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 85,575.1 сая төгрөгөөр баталж, төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

2024 оны Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтэй уялдуулан аймаг, сумдын төсөвт 1 удаа төсвийн тодотгол, жилийн эцэст 2 удаа төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн тодотголын суурь орлогыг аймаг, сумдын ИТХ-ын 2024 оны төсвийн тодотгол болон төсвийн зохицуулалтаар нийт 147,524.9 сая төгрөгөөр, үүнээс татварын орлогыг 142,648.0 сая төгрөг, татварын бус орлогыг 4,876.9 сая төгрөгөөр буюу суурь орлогыг 61,949.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Орон нутгийн төсвийн суурь орлого – Тодотгосон төсөв

Хүснэгт №2 /сая төгрөг/

Орлогын төрөл	Сангийн яамны хянасан орлого	ИТХ-аар баталсан орлого			Нэмэгдүүлсэн дүн
		Аймгийн дүн	Сумын дүн	Нийт дүн	
Татварын орлого	82,528.5	62,079.2	80,568.8	142,648.0	60,119.5
Татварын бус орлого	3,046.6	1,611.3	3,265.6	4,876.9	1,830.3
ДҮН	85,575.1	63,690.5	83,834.4	147,524.9	61,949.8

МУ-ын Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "Жилийн төсвийн хязгаар гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн ТЕЗ-ийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээ" гэж заасан.

Аймгийн орон нутгийн орлогын төсвийг батлахдаа ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг 219.9 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны

төлбөрийг 325.1 сая төгрөгөөр, газрын тосны орлогыг 100.0 сая төгрөгөөр тус тус суурь орлогын баталсан доод хэмжээнээс бууруулан баталсан байна.

Төсвийн тодотголоор аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 63,690.5 сая төгрөгөөр буюу өөрчлөлт оруулаагүй, сумдын төсвийн орлогын төлөвлөгөөг 83,834.4 сая төгрөгөөр буюу 14,380.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн **нийт орлогыг 147,524.9** сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор татварын орлогыг 15,769.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, татварын бус орлогыг 1,388.6 сая төгрөгөөр бууруулан нэмэлт өөрчлөлт хийсэн байна.

Орон нутгийн төсвийн суурь орлогын 96.7 хувийг татварын орлогоос, 3.3 хувийг татварын бус орлогоос бүрдүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн төсвийн суурь орлого

Хүснэгт №3	/сая төгрөг/		
	Батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Өөрчлөлт
Аймгийн төвийн орлого	63,690.5	63,690.5	-
Сумдын орлого	69,454.0	83,834.4	14,380.4
ОН-ийн орлогын дүн	133,144.5	147,524.9	14,380.4

Орлогын төлөвлөгөөний өөрчлөлтийг авч үзэхэд: цалин хөлс, түүнтэй адилтгах бусад орлогыг 5,328.2 сая, хадгаламжийн хүүгийн орлогыг 10.4 сая, үйл ажиллагааны орлогын албан татварыг 315.5 сая, хувь хүнээс суутгасан орлогын албан татварыг 2,613.1 сая, хадгаламжийн хүүгийн орлогын албан татварыг 350.7 сая, хөрөнгө борлуулсны орлогын албан татварыг 239.7 сая, үл хөдлөх хөрөнгийн татварыг 2,047.8 сая, галт зэвсгийн албан татварыг 0.6 сая, улсын тэмдэгтийн хураамжийг 5,121.7 сая, ан агнах зөвшөөрлийн хураамжийг 225.1 сая, хог хаягдлын хураамжийг 1.0 сая, газрын төлбөрийг 208.0 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 1.0 сая төгрөгөөр **тус тус нэмэгдүүлж**, малын тоо толгойн албан татварыг 181.2 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 501.2 сая, торгуулийн орлогыг 532.0 сая, нэр зааж ангилагдаагүй орлогыг 857.6 сая төгрөгөөр **тус тус бууруулж** баталсан байна.

Тайлант хугацаанд сумдын төсвийн орлогыг баталсан төлөвлөгөө, гүйцэтгэлийг авч үзэхэд орлогын хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн тооцоо судалгаагүйгээр нэмэгдүүлж, бууруулсан байна.

Сумын ИТХ-аар баталдаг хог хаягдлын хураамж, малын тоо толгойд ногдуулсан татвар, газрын төлбөр зэрэг татварын орлогын хэмжээг холбогдох байгууллагын тооцоо судалгаагүйгээр тодотголоор нэмэгдүүлж, бууруулан баталж байгаа нь орлогыг бодитой төлөвлөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Аймаг, сумдын ИТХ нь Сангийн яамны хянасан суурь орлогыг 2022 онд 64,877.0 сая төгрөгөөр, 2023 онд 50,203.1 сая төгрөгөөр, 2024 онд 61,949.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл татварын орлогыг 30,807.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, татварын бус орлогыг 3,341.1 сая төгрөгөөр бууруулж, өмнөх оноос нийт 27,466.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Орон нутгийн төсвийн суурь орлого

Хүснэгт №4		/сая төгрөг/		
Д/д	Орлогын нэр төрөл	Орлого		
		2022	2023	2024
1	Татварын орлого	101,486.2	111,840.4	142,648.0
2	<i>Орлогын албан татвар</i>	<i>24,920.9</i>	<i>33,919.9</i>	<i>47,624.9</i>
3	Хувь хиний орлогын албан татвар	25,725.7	34,825.1	48,924.9
4	Хувь хиний орлогын албан татварын буцаан олголт	(804.8)	(905.2)	(1,300.0)
5	<i>ААН-ийн орлогын албан татвар</i>	<i>6,610.0</i>	<i>21,910.0</i>	<i>31,000.0</i>

6	Хөрөнгийн албан татвар	3,264.7	3,659.8	6,246.7
7	Бусад татвар, төлбөр, хураамж	66,690.6	52,350.7	57,776.4
8	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,635.4	7,398.2	19,266.6
9	Газрын төлбөр	7,831.2	5,744.3	6,921.6
10	Дуудлага худалгаа	52,401.1	37,516.0	30,000.0
11	Байгалийн нөөц ашигласны төлбөр	822.9	1,692.2	1,588.2
12	Татварын бус орлого	5,826.5	8,218.0	4,876.9
13	Нийтлэг татварын бус орлого	5,796.5	8,203.0	4,846.9
14	Хөрөнгийн орлого	30.0	15.0	30.0
Нийт орлогын дүн		107,312.7	120,058.4	147,524.9

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор аймгийн **2024 оны орон нутгийн төсвийн зардлыг санхүүжүүлэх нийт эх үүсвэрийг 180,270.7** сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор нийт 15,925.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, **196,196.5 сая төгрөгөөр баталсан байна.**

2024 оны орон нутгийн төсвийн нийт санхүүжүүлэх

Хүснэгт №5

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Батлагдсан төсөв			
		Анх батлагдсан	Тодотгосон	Зохицуулалт	өөрчлөлт
1	Татварын орлого	126,878.9	143,148.0	142,648.0	15,769.0
2	Татварын бус орлого	5,946.8	4,057.2	4,557.2	(1,389.6)
3	Өөрийн орлого	318.7	319.7	319.7	1.0
4	ОНХНС-ийн санхүүжилт	41,298.3	42,708.1	42,708.1	1,409.8
5	ОНХС - орлого	1,884.0	1,904.0	1,904.0	20.0
6	ХХС - орлого	784.7	776.0	776.0	(8.7)
7	НСС - орлого	39.5	45.7	45.7	6.2
8	ОНХС - урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,491.8	1,491.4	1,491.4	(0.4)
9	ХХС - урьд оны үлдэгдлээс санхүүжих	989.7	1,006.8	1,006.8	17.1
10	НСС - урьд оны үлдэгдлээс санхүүжих	388.2	388.2	388.2	-
11	ЕД-ны урьд оны үлдэгдлээс санхүүжих ОНХО	250.0	351.4	351.4	101.4
Нийт орлого		180,270.7	196,196.5	196,196.5	15,925.8

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль болон ИТХ-аар баталсан төсвийн өөрчлөлтөөр аймгийн төсвийн орлогын эх үүсвэрийн төлөвлөгөөнд дараах өөрчлөлтүүдийг хийсэн байна. Үүнд: ОН-ийн төсвийн санхүүжилтийг 14,380.4 сая, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогын санхүүжилтийг 1.0 сая, ОНХНС-аас аймгийн төсөвт олгох орлогын шилжүүлгийг 1,409.8 сая, тусгай сангуудын орлогыг 17.5 сая, урьд оны үлдэгдлийн санхүүжилтийг 118.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

1.2. Дорноговь аймгийн 2024 оны төсвийн нийт зарлагыг 85,894.5 сая төгрөгөөр төлөвлөн төсвийн санал боловсруулж, Сангийн яаманд хүргүүлж, Сангийн яамнаас 2024 оны төсвийн орон нутгийн суурь зарлагыг 45,008.4 сая төгрөгөөр буюу төсвийн саналаас 40,886.1 сая төгрөгөөр бууруулж, 2024 оны төсвийн тодотголоор суурь зарлагыг 46,329.0 сая төгрөг байхаар хянасан байна.

МУ-ын Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “*Жилийн төсвийн хязгаар гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдээдэлд нийцүүлэн ТЕЗ-ийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээ*” гэж заасан.

Сангийн яамнаас хянаж ирүүлсэн суурь зарлагыг аймаг, сумдын ИТХ-ын 2023 оны “2024 оны төсөв батлах тухай” тогтоолоор нийт 79,054.9 сая төгрөгөөр, 2024 оны төсвийн тодотголоор суурь зарлагыг нийт 89,773.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн орон нутгийн зарлагыг нийт 136,102.5 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсвийн суурь зарлагын төлөвлөгөө

Хүснэгт №6

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Сангийн яамны хянасан төсөв		ИТХ-аар баталсан			төсвийн зохицуулалт	
	2023.11.13	2024.08.30	Анхны төсөв	Төсвийн тодотгол	Зөрүү	Төсвийн зохицуулалт	Зөрүү
Аймгийн ИТХ	731.9	731.9	2,137.2	2,137.2	-	2,137.2	-
Сумын ИТХ	2,615.8	2,615.8	3,136.2	3,358.7	222.4	3,383.0	-
Аймгийн ЗДТГ	9,539.0	9,539.0	6,675.2	7,175.2	500.0	8,000.2	(538.8)
Сумын ЗДТГ	11,333.0	11,333.0	20,287.2	21,258.4	971.1	21,204.6	(50.0)
Хот тохижуулах газар	1,625.3	1,625.3	2,464.9	2,450.9	(14.0)	2,452.5	-
Захирагчийн ажлын алба	-	-	5,378.5	5,850.5	472.0	5,878.3	-
ОНӨГазар	277.2	277.2	456.0	456.0	-	456.0	(11.2)
ХАА-ны газар	-	-	388.3	412.2	23.9	412.2	11.2
БОГазар	1,636.7	1,624.1	1,650.4	2,022.0	371.5	2,022.0	4.4
СХАА	323.5	323.5	596.1	606.1	10.0	606.1	0.4
НҮГ	143.6	143.6	1,503.2	1,503.2	-	1,534.6	-
НХҮХэлтэс	-	-	146.4	146.4	-	146.4	-
Засаг дарга – Урсгал зардал	2,168.3	2,168.3	15,500.6	17,220.7	1,720.1	18,896.1	361.9
Засаг дарга /Хөрөнгийн зардал/ - ОНХО	2,790.6	2,790.6	40,514.7	44,352.7	3,838.0	44,352.7	-
ОНБ-уудын үйлчилгээ ашиглалт	12,644.3	13,977.5	14,666.2	15,525.3	859.2	12,993.5	(1,042.0)
Гадаад зээл тусламжийн эргэн төлөлт	(959.8)	(959.8)	(959.8)	(959.8)	-	(959.8)	1,200.5
Аймгийн ОНХСанд олгох санхүүжилт	-	-	-	-	-	-	-
Сумдын ОНХСанд олгох санхүүжилт	-	-	1,940.8	2,834.1	893.3	2,834.1	50.0
Замын Үүд сумын орон нутгийн хөрөнгө оруулалт	-	-	6,875.9	9,047.5	2,171.7	9,047.5	-
Замын Үүд сумын ойн анги	138.9	138.9	705.3	705.3	-	705.3	-
Орон нутгийн суурь зарлага	45,008.4	46,329.0	124,063.3	136,102.5	12,039.2	136,102.5	-

Сангийн яамны хянасан орон нутгийн төсвийн суурь зарлагын тодотгосон төлөвлөгөөг аймаг, сумдын ИТХ-аар баталсан төсвийн тодотгол болон төсвийн зохицуулалтаар хийгдсэн өөрчлөлтийг авч үзэхэд аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын урсгал зардлыг 36,329.7 сая, сумдын ОНХС-д олгох орон нутгийн орлогын санхүүжилтийг 2,834.1 сая, ОНХО-ын зардлыг 50,609.7 сая төгрөгөөр, нийт 89,773.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн нийт зарлагыг 124,063.3 сая төгрөгөөр батлан, төсвийн нэмэлт өөрчлөлтөөр нийт 12,039.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 136,102.5 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн 2024 оны төсвийн зарлагын төлөвлөгөөг өмнөх оны төлөвлөгөөтэй харьцуулж үзэхэд 14 төрлийн зардлыг нийт 35,601.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 5 төрлийн зардлыг 12,068.4 сая төгрөгөөр бууруулсан байх ба орон нутгийн зарлагын төлөвлөгөө өмнөх оноос нийт дүнгээрээ 7,138.3 сая төгрөгөөр өссөн байна.

Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө

Хүснэгт №7

/сая төгрөг/

Д/д	Зарлагын төрөл	2022 он	2023 он	2024 он	Өөрчлөлт
1	Аймаг, сумын ИТХ	2,740.5	4,312.0	5,495.9	1,183.9
2	Аймаг, сумын ЗДТГ	14,707.5	20,109.4	28,433.5	8,324.1
3	Хот тохижуулах газар	2,748.7	1,643.4	2,450.9	807.5
4	Захирагчийн ажлын алба	422.9	3,961.5	5,850.5	1,889.0
5	Орон нутгийн өмчийн газар	225.3	332.2	456.0	123.8
6	Худалдан авах ажиллагааны газар	-	11.2	412.2	401.0

7	Байгаль орчныг хамгаалах газар	1,350.9	1,879.5	2,022.0	142.5
8	Санхүүгийн хяналт, аудитын алба	228.0	361.7	606.1	244.4
9	Нийтлэг үйлчилгээний газар	729.3	1,084.3	1,503.2	418.9
10	Халамжийн сан	146.4	146.4	146.4	-
11	Засаг дарга-Урсгал зардал	4,530.7	8,002.4	17,220.7	9,218.3
12	Засаг дарга-Хөрөнгийн зардал	55,200.7	50,942.5	44,352.7	(6,589.8)
13	Насан туршийн боловсрол	89.4	-	-	-
14	ОНБ-уудын үйлчилгээ ашиглалт	10,187.5	9,469.6	15,525.3	6,055.7
15	Гадаад зээл тусламжийн эргэн төлөлт	(2,106.0)	-	(959.8)	(959.8)
16	Аймгийн ОНХСанд олгох санхүүжилт	5,897.6	-	-	-
17	Сумдын ОНХСанд олгох санхүүжилт	1,306.9	1,720.6	2,834.1	1,113.5
18	Замын Үүд сумын орон нутгийн хөрөнгө оруулалт	2,293.0	3,619.7	9,047.5	5,427.8
19	Замын Үүд сумын ойн анги	212.9	454.1	705.3	251.2
Нийт дүн		100,912.2	108,050.5	136,102.5	28,052.0

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг Сангийн яамнаас хянасан дүнгээр буюу аймгийн ИТХ-ын 2023 оны “2024 оны төсөв батлах тухай” тогтоолоор нийт 9,331.1 сая төгрөгөөр, 2024 оны төсвийн тодотголоор 2,442.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн **11,773.8 сая төгрөгөөр баталсан байна.**

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор аймгийн **2024 оны төсвийн нийт зардлыг** 180,270.7 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор нийт 15,925.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, **196,196.5 сая төгрөгөөр баталсан байна.** Үүнд: Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын урсгал зардлыг 66,874.6 сая, тусгай сангуудын зардлыг 51,154.4 сая, ОНХО-ын зардлыг 53,400.3 сая, орон нутгийн байгууламжийн үйлчилгээ ашиглалтын зардлыг 12,993.5 сая, улсын төсөвт татан төвлөрүүлэх орлогыг 11,773.8 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

2024 оны орон нутгийн төсвийн нийт зардал

Хүснэгт №8

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Батлагдсан төсөв			
		Анх	Тодотгосон	Зохицуулалт	Өөрчлөлт
1	АИТХ	2,137.2	2,137.2	2,137.2	-
2	СИТХ	3,136.2	3,358.7	3,383.0	246.8
3	АЗДТГ	6,675.2	7,175.2	8,000.2	1,325.0
4	СЗДТГ	20,287.2	21,258.4	21,204.6	917.3
5	Хот тохижилт	2,464.9	2,450.9	2,452.5	(12.4)
6	Захирагчийн ажлын алба	5,378.5	5,850.5	5,878.3	499.8
7	ОНӨГазар	456.0	456.0	456.0	-
8	Худалдан авах ажиллагаа	388.3	412.2	412.2	23.9
9	БОГазар	1,650.4	2,022.0	2,022.0	371.5
10	СХАА	596.1	606.1	606.1	10.0
11	НҮГ	1,503.2	1,503.2	1,534.6	31.5
12	НХҮХэлтэс	146.4	146.4	146.4	-
13	ОНБ-уудын үйлчилгээ ашиглалт	14,666.2	15,525.3	12,993.5	(1,672.7)
14	Гадаад зээл тусламжийн эргэн төлөлт	(959.8)	(959.8)	(959.8)	-
15	Засаг дарга	15,500.6	17,220.7	18,896.1	3,395.5
16	Аймгийн ОНХОруулалт	40,514.7	44,352.7	44,352.7	3,838.0
17	Замын Үүдийн орон нутгийн хөрөнгө оруулалт	6,875.9	9,047.5	9,047.5	2,171.7
18	Замын Үүдийн ойн анги	705.3	705.3	705.3	-
19	Улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг	9,331.2	11,773.8	11,773.8	2,442.7
20	ОНХС-д орон нутгийн орлогоос олгох	1,940.8	2,834.1	2,834.1	893.3
21	ОНХС-д олгох бусад санхүүжилт	44,674.1	46,103.6	46,103.6	1,429.4
22	ХХС	1,774.4	1,782.8	1,782.8	8.4
23	НСС	427.7	433.9	433.9	6.2
Нийт зардал		180,270.7	196,196.5	196,196.5	15,925.8

Төсвийн тодотгол, төсвийн зохицуулалтаар аймгийн төсвийн зарлагын төлөвлөгөөнд дараах өөрчлөлтүүдийг хийсэн байна. Үүнд: аймгийн ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын урсгал зардлыг 6,808.8 сая, тусгай сангуудын зардлыг 2,337.3 сая, ОНХО-ын зардлыг 6,009.7 сая, улсын төсөвт татан төвлөрүүлэх орлогыг 2,442.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, орон нутгийн байгууламжийн үйлчилгээ ашиглалтын зардлыг 1,672.7 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аймгийн орон нутгийн төсвийн орлогыг 147,524.9 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 115,934.7 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн, 31,591.2 сая төгрөгөөр тасарч, орлогын төлөвлөгөө 78.6 хувиар биелсэн байна.

Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Орлогын нэр төрөл	Тайлант он						/сая төгрөг/	
	Аймгийн орлого		Сумдын орлого		Төсвийн нийт орлого		Төлөвлөгөө гүйцэтгэлийн	
	Төл-гөө	Гүй-гэл	Төл-гөө	Гүй-гэл	Төл-гөө	Гүй-гэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	62,079.2	27,624.2	80,568.8	81,111.6	142,648.0	108,735.8	33,912.2	76.2
Татварын бус орлого	1,611.3	2,584.1	3,265.6	4,614.9	4,876.9	7,198.9	(2,322.0)	147.6
НИЙТ ОРЛОГО	63,690.5	30,208.3	83,834.4	85,726.4	147,524.9	115,934.7	31,590.2	78.6

Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг авч үзэхэд татварын орлого 44.5 хувь, татварын бус орлого 160.4 хувь, **нийт хэрэгжилт 47.4 хувьтай**, сумдын орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг авч үзэхэд татварын орлого 100.7 хувь, татварын бус орлого 141.3 хувь, **нийт хэрэгжилт 102.3 хувьтай** байна.

Татварын болон татварын бус орлогын нэр төрлөөрх биелэлтийн тайлбарыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитад дэлгэрэнгүй тусгасан болно.

Орлогын төлөвлөгөөний биелэлт 78.4 хувь байгаа нь Мандах, Өргөн, Улаанбадрах, Хатанбулаг сумдын болон аймгийн орлогын төлөвлөгөө нийт 35,636.4 сая төгрөгөөр тасарснаас тус тус шалтгаалсан бөгөөд энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх үүрэг хүлээнэ” гэсэн заалтын дагуу Мандах, Өргөн, Хатанбулаг сумд аймагт татан төвлөрүүлэх орлогыг 649.3 сая төгрөгөөр, аймаг улсад төсөвт төвлөрүүлэх орлогыг 8,673.8 сая төгрөгөөр тус тус дутуу төвлөрүүлсэн байна.

Орлого тасрахад голчлон нөлөөлсөн орлого нь аж ахуй нэгжийн орлогын албан татвар болон дуудлага худалдааны орлого бөгөөд нийт 37,721.0 сая төгрөгөөр тасарсан байна.

- Газрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хуульд заасны дагуу аймаг, сумын хэмжээнд газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх асуудал газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хот хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнүүд хийгдээгүй нөхцөлд шийдвэрлэх боломжгүй болсон, мөн аймгийн ИТХ-аас орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй нэмж төлөвлөж байгаа зэрэгтэй холбоотойгоор дуудлага худалдааны орлого 25,789.4 сая төгрөгөөр,
- Аймагт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компанийн улсын төсөвт төвлөрүүлэх орлого дутуу төвлөрсөнтэй холбоотой аж ахуй нэгжийн орлогын албан татвар 11,931.6 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Сумдын орон нутгийн орлогоос аймгийн төсөвт 2024 онд татан төвлөрүүлэх орлогын хэмжээг 32,913.0 сая төгрөг байхаар баталж, 8,621.3 сая төгрөг нэмэгдүүлэн 41,534.4 сая төгрөг болгон тодотгож гүйцэтгэлээр 45,995.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 4,460.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 4 сум 5,110.0 сая төгрөгөөр илүү, 3 сум 649.3 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Сумдын төсвөөс аймгийн төсөвт татан төвлөрүүлсэн санхүүжилт

Хүснэгт №10

/сая төгрөг/

Д/д	Сумын нэр	Төсөвт төвлөрүүлэх орлого			Зөрүү /Илүү -, Дутуу+ /
		Бат/төсөв	Тод/төсөв	төвлөрүүлсэн санхүүжилт	
1	Даланжаргалан	3,729.4	6,739.9	7,807.4	(1,067.4)
2	Мандах	-	533.9	244.0	289.9
3	Өргөн	263.8	388.1	358.6	29.6
4	Хатанбулаг	921.1	2,563.8	2,233.9	329.9
5	Хөвсгөл	297.4	1,016.3	2,085.2	(1,068.8)
6	Сайншанд	13,042.0	12,773.5	13,893.0	(1,119.5)
7	Замын-Үүд	14,659.4	17,518.8	19,373.0	(1,854.3)
Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын дүн		32,913.0	41,534.4	45,995.0	(4,460.7)

2.2. Тайлант онд аймгийн ТЕЗ түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагааны орлогыг 319.7 сая төгрөгөөр төлөвлөж, хэрэгжилт 1.6 дахин их буюу 500.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №11

/сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Сумдын ЗДТГ	34.1	173.9	(139.7)	509.1
2	Захирагчийн ажлын алба	62.0	55.8	6.2	90.1
3	Аймгийн Засаг даргын харьяа байгууллагууд	223.6	270.4	(46.8)	120.9
Нийт дүн		319.7	500.1	(180.4)	156.4

Аймгийн ТЕЗ-ийн харьяа 13 байгууллагын орлого 193.1 сая төгрөгөөр давж, 5 байгууллагын орлого 12.7 сая төгрөгөөр тасарсан байна.

2.3. Аймгийн төсвийн орлогын эх үүсвэр нийт 196,196.5 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 158,567.8 сая төгрөгийг бүрдүүлэн, төлөвлөгөөний биелэлт 80.8 хувьтай байна.

Орлогын эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №12

/сая төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Орлогын гүйцэтгэл	Зөрүү	хувь
Татварын орлого	142,648.0	108,735.8	33,912.2	76.2
Татварын бус орлого	4,557.2	6,698.8	(2,141.6)	147.0
Төсөвт байгууллагуудын өөрийн орлого	319.7	500.1	(180.4)	156.4
ОНХНС-ийн санхүүжилт	42,708.1	40,852.2	1,855.9	95.7
Тусгай сангуудын орлого	2,725.7	1,780.9	944.9	65.3
Урьд оны үлдэгдлээс санхүүжих -Тусгай сангууд	2,886.4	-	2,886.4	-
ЕД-ны урьд оны үлдэгдлээс санхүүжих	351.4	-	351.4	-
Нийт орлого	196,196.5	158,567.8	37,628.8	80.8

Нийт орлогын эх үүсвэрийн 72.8 хувийг татварын болон татварын бус орлого, 25.8 хувийг ОНХС-ийн санхүүжилт, 1.4 хувийг үйл ажиллагааны орлогын санхүүжилт тус тус эзэлж байна.

Аймаг сумдын ИТХ-ын тогтоолоор ОНХС-ийн бусад орлогыг 1,904.0 сая төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлэх хөрөнгийг 776.0 сая төгрөг, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх барьцаа хөрөнгийг 45.7 сая төгрөгөөр тус тус төлөвлөж, гүйцэтгэлээр ОНХС-ийн бусад орлого 273.7 сая төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлого 1,221.2 сая төгрөг, нөхөн сэргээлтийн тусгай дансны барьцаа хөрөнгөөс 286.0 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

Тусгай сангуудын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №13

/сая төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Орлогын гүйцэтгэл	Зөрүү
Хоршоо хөгжүүлэх сан	776.0	1,221.2	(445.2)
Нөхөн сэргээлтийн сан	45.7	286.0	(240.3)
Орон нутгийн хөгжлийн сан	1,904.0	273.7	1,630.4
Нийт	2,725.7	1,780.9	944.9

ХХС-ийн орлого 12.6 сая төгрөгөөр, НСС-ийн тусгай дансны орлого 175.1 сая төгрөгөөр тус тус давсан байна. Энэ нь хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт болон хугацаа хэтэрсэн зээлийн төлөлтийг шүүхийн шийдвэрээр барагдуулсантай холбоотой байна. Мөн сумдад хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хугацаанд нь батлуулж барьцаа хөрөнгийг байршуулсантай холбоотойгоор НСС-ийн орлого давж биелсэн байна.

Аймгийн ОНХС-д төвлөрүүлэхээр тооцоолсон хандивын орлого 1,636.0 сая төгрөгөөр биелээгүй нь ОНХС-ийн нийт орлого 1,630.4 сая төгрөгөөр тасрахад нөлөөлсөн байна.

БҮЛЭГ 3: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

3.1. Дорноговь аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн нийт суурь зарлагыг 136,102.5 сая төгрөгөөр баталснаас 109,944.6 сая төгрөг буюу 80.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн зарлагын гүйцэтгэл

Хүснэгт №14

/сая төгрөг/

№	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	АИТХ	2,137.2	2,136.0	1.2	99.9
2	СИТХ	3,383.0	3,116.3	266.7	92.1
3	АЗДТГ	8,000.2	6,092.0	1,908.2	76.1
4	СЗДТГ	21,204.6	19,790.9	1,413.7	93.3
5	Хот тохижилт	2,452.5	2,319.4	133.2	94.6
6	Захирагчийн ажлын алба	5,878.3	5,586.8	291.4	95.0
7	ОНӨГазар	456.0	335.3	120.7	73.5
8	Худалдан авах ажиллагаа	412.2	371.0	41.1	90.0
9	БОГазар	2,022.0	1,824.8	197.2	90.2
10	СХАА	606.1	521.5	84.6	86.0
11	НҮГ	1,534.6	1,531.1	3.5	99.8
12	НХҮХэлтэс	146.4	90.2	56.2	61.6
13	ОНБ-уудын үйчилгээ ашиглалт	12,993.5	11,930.2	1,063.3	91.8
14	Гадаад зээл тусламжийн эргэн төлөлт	(959.8)	-	(959.8)	-
15	Засаг дарга	18,896.1	13,916.6	4,979.5	73.6
16	Аймгийн ОНХОруулалт	44,352.7	30,741.1	13,611.6	69.3
17	Замын Үүдийн орон нутгийн хөрөнгө оруулалт	9,047.5	7,142.6	1,904.9	78.9
18	Замын Үүдийн ойн анги	705.3	608.4	96.9	86.3
19	ОНХС-д орон нутгийн орлогоос олгох	2,834.1	1,890.5	2,834.1	-
	Орон нутгийн суурь зарлага	136,102.5	109,944.6	26,157.8	80.8

Орон нутгийн нийт суурь зардлын 58,240.1 сая төгрөгийг харьяа төсөвт байгууллагуудын зарцуулалт, 11,930.3 сая төгрөгийг ОНӨ-т байгууламжийн ашиглалтын зардал, 1,890.5 сая төгрөгийг сумдын ОНХС-д олгосон санхүүжилт, 37,883.8 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалтын зардалд тус тус зарцуулсан байна.

Орон нутгийн нийт суурь зарлага 26,157.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь орон нутгийн татварын болон татварын бус орлого нийт дүндээ 31,590.2 сая төгрөгөөр тасарсантай холбоотой байна.

3.2. Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 41,298.3 сая төгрөгийг олгохоор баталж, төсвийн тодотголоор 1,409.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 42,708.1 сая төгрөгөөр батлан, гүйцэтгэлээр 40,852.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт

Хүснэгт №15 /сая төгрөг/

№	Эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ОНХНС-аас олгох	42,708.1	40,852.2	1,855.9
2	Бусад орлого /хандив/	1,904.0	273.6	1,630.4
3	Орон нутгийн төсвийн орлогоос санхүүжих	2,834.1	1,890.5	943.5
4	Оны эхний үлдэгдлээс	1,491.4	-	1,491.4
Дүн		48,937.6	43,016.4	5,921.2
1	ОНХС-ийн зарцуулалт	48,937.6	42,016.0	6,921.6
	<i>МХ-н эхний үлдэгдэл</i>	-	2,825.2	-
	<i>МХ-н эцсийн үлдэгдэл</i>	-	3,825.6	-

ОНХНС-аас аймгийн ОНХС-д 31,627.8 сая төгрөгөөс 30,468.0 сая төгрөгийн, сумдын ОНХС-д 11,080.3 сая төгрөгөөс 10,384.2 сая төгрөгийн, орон нутгийн төсвийн орлогоос сумдын ОНХС-д 2,834.1 сая төгрөгөөс 1,890.5 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож, бусад орлогоос 273.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэн нийт санхүүжилт 43,016.4 сая төгрөг байна.

ОНХС-ын зардлын нийт гүйцэтгэл 42,016.0 сая төгрөг буюу 85.9 хувийн биелэлттэй, нийт санхүүжилтээс 1,000.4 сая төгрөг зарцуулагдаагүй үлдэж жилийн эцэст 3,825.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хоршоо хөгжүүлэх болон нөхөн сэргээх сангийн 2024 оны батлагдсан төсөв нийт 2,216.7 сая төгрөг бөгөөд өмнө оны үлдэгдлээс 1,395.0 сая төгрөгийг, сангийн орлогоос 821.7 сая төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдсан байна.

Тайлант онд нийт 1,509.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэн, 188.4 сая төгрөгийг зарцуулан харилцах дансны үлдэгдэл 1,320.8 сая төгрөгөөр өсөж 3,150.4 сая төгрөг болсон байна.

ХХС болон НСС-ийн зарцуулалт

Хүснэгт №16 /сая төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төсөв			Орлогын гүйцэтгэл	Зөрүү	Зардлын гүйцэтгэл	МХ-н эхний үлдэгдэл	МХ-н эцсийн үлдэгдэл
	Оны эхний үлдэгдэл ээс	Тайлант оны орлогоос	Нийт					
Хоршоо хөгжүүлэх сан	1,006.8	776.0	1,782.8	1,221.2	(445.2)	173.1	1,267.7	2,315.9
Нөхөн сэргээлтийн сан	388.2	45.7	433.9	288.0	(242.3)	15.3	561.9	834.5
Нийт	1,395.0	821.7	2,216.7	1,509.2	(687.5)	188.4	1,829.6	3,150.4

Тайлант онд ХХС-ийн зээлийн эргэн төлөлтийн орлого 1,221.2 сая төгрөг бөгөөд төлөвлөгөөнөөс 445.2 сая төгрөгөөр давсан байна. Харин зардлын гүйцэтгэл 173.1 сая төгрөг байгаагаас 162.7 сая төгрөгийг шинээр зээл олгоход, 10.3 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,315.9 сая төгрөг байна. НСС-ийн орлого 288.0 сая төгрөг бөгөөд 242.3 сая төгрөгөөр давж, зардлын гүйцэтгэл 15.3 сая төгрөгийг зориулалтын дагуу үйл ажиллагаанд зарцуулсан бөгөөд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 834.5 сая төгрөг байна.

Сайншанд сумын НСС-ийн орлого, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланд татагдаж ордоггүйгээс нэгтгэл тайлангийн дүн зөрүүтэй гарч байна. Энэ нь тайлангийн нэгтгэлийн программтай холбоотой алдаа болно.

3.3. Дорноговь аймгийн 2024 оны төсвийн нийт зарлага /аймаг, сумдын нийт дүнгээр/ тодотгосон төсвөөр 196,196.5 сая төгрөгөөр батлагдсанаас 153,358.5 сая төгрөг буюу 78.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зардлын гүйцэтгэл /эдийн засгийн ангиллаар/

Хүснэгт №17

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2024 он			
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	133,119.2	196,196.5	153,358.5	42,838.0	78.2
УРСГАЛ ЗАРДАЛ	92,649.7	142,596.3	115,420.3	27,176.0	80.9
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	15,687.5	26,894.3	25,950.9	943.5	96.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,942.3	3,444.9	3,208.7	236.3	93.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,439.1	14,097.2	12,944.1	1,153.1	91.8
Хангамж, бараа материалын зардал	1,652.4	1,814.6	1,736.2	78.4	95.7
Нормативт зардал	220.4	350.6	349.5	1.1	99.7
Эд хогшил, урсгал засварын зардал	1,882.1	2,164.9	2,092.7	72.3	96.7
Томилолт, зочны зардал	256.6	388.8	310.0	78.7	79.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,957.0	28,586.9	21,013.0	7,574.0	73.5
Бараа үйлчилгээний бусад зардал	2,744.0	1,273.5	619.9	653.6	48.7
Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр	300.0	577.7	-	577.7	-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	294.0	200.0	200.0	-	100.0
Урсгал шилжүүлэг	46,274.2	62,802.8	46,995.4	15,807.4	74.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,469.5	53,600.3	37,938.3	15,662.0	70.8

Орон нутгийн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг авч үзвэл бараа, үйлчилгээний зардал 44.6 хувь, урсгал шилжүүлэг 30.6 хувь, хөрөнгийн зардал 24.7 хувийн гүйцэтгэлтэй буюу нийт зардлыг 42,838.0 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Зарим зардлын хэмнэлтийн шалтгааныг авч үзвэл дараах байдалтай байна.

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардал нийт дүнгээр 943.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь аймгийн ЗДТГ, ИТХ болон харьяа орон нутгийн төсвийн байгууллагууд бүтэц орон тоогоор бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй улмаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын нэмэгдэл хэмнэлт үүссэн.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,153.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх зорилт 1.15.1-д “сумдыг төвлөрсөн дулаан хангамжид үе шаттай холбох” заалтын дагуу алслагдмал 10 сумыг төвлөрсөн шугамд холбож ашиглалтад оруулж, 2024 онд Замын-Үүд сумын ЕБ-н 1 дүгээр сургуулийн шинэ байр, Замын-Үүд 640 хүүхдийн сургууль ашиглалтад ороогүйн улмаас тогтмол зардалд хэмнэлт үүссэн, Төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлж сургууль, цэцэрлэгийг ажиллахгүй байгаа үед цахилгаанаар халдаг горимд шилжүүлэх, сургууль, цэцэрлэгийн халаах талбайн хязгаарлалт хийх гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлэх арга хэмжээ авч ажилласнаар хэмнэгдсэн.
- Аймгийн орлого тасарсантай холбоотой байгууллагууд болон хөрөнгө оруулалтын санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой бусад зардлын хэмнэлт үүссэн байна.

3.4. Аймгийн төсвөөс 8 суманд 4,247.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор баталж, төсвийн тодотголоор 1,042.6 сая төгрөгөөр бууруулан 7 суманд 3,205.2 сая төгрөгөөр баталснаас 2,314.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон байна.

Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг

Хүснэгт №18

/сая төгрөг/

Д/д	Сумын нэр	Санхүүгийн дэмжлэг			Зөрүү	Хувь
		Бат/төсөв	Тод/төсөв	олгосон санхүүжилт		
1	Айраг	378.0	178.6	83.9	94.7	47.0
2	Алтанширээ	181.8	227.0	68.0	159.0	29.9
3	Дэлгэрэх	846.9	750.2	638.8	111.3	85.2
4	Иххэт	804.2	556.5	252.4	304.1	45.4
5	Мандах	130.0	-	-	-	#DIV/0!
6	Сайхандулаан	792.8	706.3	646.5	59.8	91.5
7	Улаанбадрах	701.2	558.1	608.4	(50.4)	109.0
8	Эрдэнэ	412.9	228.7	16.2	212.4	7.1
Нийт дүн		4,247.8	3,205.2	2,314.3	890.9	72.2

Тайлант онд сумдын орон нутгийн төсвийн орлого нийт 756.1 сая төгрөгөөр давж биелсэн, байгууллагууд үйл ажиллагааны зардлыг хэмнэсэнтэй холбоотой сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг дутуу олгосон байна. Үүнээс 6 суманд 941.3 сая төгрөгийг дутуу олгож, 1 суманд 50.4 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байна.

3.5. Аймгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 11,773.8 сая төгрөгийг баталснаас гүйцэтгэлээр 3,100.0 сая төгрөг төвлөрүүлж, **8,673.8 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн** нь тайлант оны орон нутгийн татварын болон татварын бус орлого нийт 31,590.2 сая төгрөгөөр тасарсантай холбоотой байна.

3.6. Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтад нийт 53,400.3 сая төгрөгийн төсөв батлагдаж 37,883.8 сая төгрөгийг зарцуулан, 70.9 хувьтай биелсэн байгаа нь орон нутгийн орлогын төлөвлөгөө биелээгүй, ТАХ-г хэрэгжүүлэгч байгууллагууд ажлаа бүрэн хийж дуусгаагүй зэрэг шалтгаан нөлөөлсөн байна.

Дорноговь аймагт хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

Хүснэгт №19

/сая төгрөг/

Төсөв захирагч	Төсөл, арга хэмжээний тоо	Санхүүжүүлэх дүн	Олгосон санхүүжилт	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
Аймаг	195	44,352.7	30,741.1	13,611.6	69.3
Замын-Үүд сум	58	9,047.5	7,142.6	1,904.9	78.9
Нийт дүн	253	53,400.3	37,883.8	15,516.5	70.9

3.7. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Хот хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хэрэгжүүлэх, хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбоотой Аймгийн засаг даргын 2024 оны А/01 захирамжаар 2024 оныг "Түншлэл-Хөгжил" жил болгон зарласан. Жилийн зорилтыг хангах үүднээс аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд орон нутгийн орлогоос бизнес эрхлэгчдийг дэмжих төслийн 1,952.9 сая төгрөгийн зээлийг 18 иргэн 8 ААН-д олгосон байна.

БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

Сангийн яамны хянасан төсвөөр аймгийн орон нутгийн орлого зардлын тэнцлийг 39,246.1 сая төгрөгөөр, аймгийн ИТХ-ын баталсан төсвөөр 11,422.4 сая төгрөгөөр тус тус батлан гүйцэтгэлээр 5,990.1 сая төгрөгийн тэнцэлтэй тайлагнагдсан байна.

Аймгийн орон нутгийн төсвийн 2024 оны тэнцэл

Хүснэгт №20

/сая төгрөг/

№	Байгууллагын нэр	Сангийн яамны хянасан төсөв	Аймаг сумдын ИТХ-аар баталсан	Гүйцэтгэл.	Зөрүү
А	Б	1	2	3	3
	Оны эхний харилцах дансны үлдэгдлээс	-	351.4	-	(0.0)
	Орон нутгийн суурь орлого	85,575.1	147,524.9	115,934.7	31,590.2
1	Татварын орлого	82,528.5	142,648.0	108,735.8	33,912.2
2	Татварын бус орлого	3,037.7	4,557.2	6,698.8	(2,141.6)
3	ТЭЗ, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого	8.9	319.7	500.1	(180.4)
	Орон нутгийн суурь зарлага	46,329.0	136,102.5	109,944.6	26,157.8
1	Аймгийн ИТХ	731.9	2,137.2	2,136.0	1.2
2	Сумын ИТХ	2,615.8	3,383.0	3,116.3	266.7
3	Аймгийн ЗДТГ	9,539.0	8,000.2	6,092.0	1,908.2
4	Сумын ЗДТГ	11,333.0	21,204.6	19,790.9	1,413.7
5	Хот тохижуулах газар	1,625.3	2,452.5	2,319.4	133.2
6	Захирагчийн ажлын алба	-	5,878.3	5,586.8	291.4
7	ОНӨГ азар	277.2	456.0	335.3	120.7
8	Худалан авах ажиллагаа	-	412.2	371.0	41.1
9	БОГазар	1,624.1	2,022.0	1,824.8	197.2
10	СХАА	323.5	606.1	521.5	84.6
11	НҮГ	-	1,534.6	1,531.1	3.5
12	НХҮХэлтэс	143.6	146.4	90.2	56.2
13	Засаг дарга	2,168.3	18,896.1	13,916.6	4,979.5
14	Засаг дарга /Хөрөнгийн зардал/ - ОНХО	2,790.6	44,352.7	30,741.1	13,611.6
15	ОНБ-уудын үйчилгээ ашиглалт	13,977.5	12,993.5	11,930.2	1,063.3
16	Гадаад зээл тусламжийн эргэн төлөлт	(959.8)	(959.8)	-	(959.8)
17	Сумдын ОНХСанд олгох орлогын шилжүүлэг	-	2,834.1	1,890.5	943.5
18	Замын Үүдийн орон нутгийн хөрөнгө оруулалт	-	9,047.5	7,142.6	1,904.9
19	Замын Үүдийн ойн анги	138.9	705.3	608.4	96.9
	НИЙТ ТЭНЦЭЛ	39,246.1	11,422.4	5,990.1	5,432.4
	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	11,773.8	11,773.8	3,100.0	8,673.8
	Орон нутагт үлдэх	27,472.3	-	2,890.1	(3,241.5)
	ОНЕО эхний үлдэгдэл	-	-	351.4	-
	ОНЕО эцсийн үлдэгдэл	-	-	3,241.5	-

Аймгийн орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг авч үзэхэд татварын болон татварын бус орлого 115,434.6 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 500.1 сая төгрөг, нийт 115,934.7 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, урсгал зардалд 72,060.9 сая төгрөгийн, хөрөнгө оруулалтын зардалд 37,883.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгон, улсын төсөвт 3,100.0 сая төгрөгийг орлогыг төвлөрүүлж, орон нутгийн орлогын үлдэгдэл 3,241.5 сая төгрөг байна.

Аймгийн төсвийн 2024 оны төсвийн нийт гүйцэтгэл

Хүснэгт №21

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Орлого				
1	Татварын орлого	142,648.0	108,735.8	33,912.2	76.2
2	Татварын бус орлого	4,557.2	6,698.8	(2,141.6)	147.0
3	Өөрийн орлого	319.7	500.1	(180.4)	156.4

4	ОНХНС-ийн санхүүжилт	42,708.1	40,852.2	1,855.9	95.7
5	ОНХС - орлого	1,904.0	273.6	1,630.4	14.4
6	ХХС - орлого	776.0	1,221.2	(445.2)	157.4
7	НСС - орлого	45.7	286.0	(240.3)	625.8
8	урьд оны үлдэгдлээс -ОНХС	1,491.4	-	1,491.4	-
9	урьд оны үлдэгдлээс -СХС	1,006.8	-	1,006.8	-
10	урьд оны үлдэгдлээс - НСС	388.2	-	388.2	-
11	ЕД-ны урьд оны үлдэгдлээс -ОНХО	351.4	-	351.4	-
Нийт орлого		196,196.5	158,567.8	37,628.8	80.8
Зарлага					
1	АИТХ	2,137.2	2,136.0	1.2	99.9
2	СИТХ	3,383.0	3,116.3	266.7	92.1
3	АЗДТГ	8,000.2	6,092.0	1,908.2	76.1
4	СЗДТГ	21,204.6	19,790.9	1,413.7	93.3
5	Хот тохижилт	2,452.5	2,319.4	133.2	94.6
6	Захирагчийн ажлын алба	5,878.3	5,586.8	291.4	95.0
7	ОНӨГазар	456.0	335.3	120.7	73.5
8	Худалдан авах ажиллагаа	412.2	371.0	41.1	90.0
9	БОГазар	2,022.0	1,824.8	197.2	90.2
10	СХАА	606.1	521.5	84.6	86.0
11	НҮГ	1,534.6	1,531.1	3.5	99.8
12	НХҮХэлтэс	146.4	90.2	56.2	61.6
13	ОНБ-уудын үйчилгээ ашиглалт	12,993.5	11,930.2	1,063.3	91.8
14	Гадаад зээл тусламжийн эргэн төлөлт	(959.8)	-	(959.8)	-
15	Засаг дарга	18,896.1	13,916.6	4,979.5	73.6
16	Аймгийн ОНХОруулалт	44,352.7	30,741.1	13,611.6	69.3
17	Замын Үүдийн орон нутгийн хөрөнгө оруулалт	9,047.5	7,142.6	1,904.9	78.9
18	Замын Үүдийн ойн анги	705.3	608.4	96.9	86.3
19	Улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг	11,773.8	3,100.0	8,673.8	26.3
20	ОНХС-д орон нутгийн орлогоос олгох	2,834.1	-	2,834.1	-
21	ОНХС-д олгох бусад санхүүжилт	46,103.6	42,016.0	4,087.5	91.1
22	ХХС	1,782.8	173.1	1,609.7	9.7
23	НСС	433.9	15.3	418.6	3.5
Нийт зардал		196,196.5	153,358.5	42,838.0	78.2
Зөрүү		-	5,209.2	(5,209.2)	
<i>Мөнгөн хөрөнгийн эхний үлэгдэл - /Сангууд+ОНЕО/</i>			4,997.6		
<i>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлэгдэл - /Сангууд+ОНЕО/</i>			10,206.8		

Аймгийн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангаар зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нийт 158,567.8 сая төгрөг, үүнээс 115,434.6 сая төгрөг нь татварын болон татварын бус орлого, 40,852.2 сая төгрөг нь ОНХНС-аас олгосон санхүүжилт, 2,280.9 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос тус тус бүрдүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 153,358.5 сая төгрөг, үүнээс ТЕЗ-ын харьяа төсөвт байгууллагуудын урсгал үйл ажиллагааны зардалд 58,240.1 сая төгрөг, тусгай сангуудын үйл ажиллагааны зардалд 42,204.4 сая төгрөг, ОНӨ-т байгууламжийн үйлчилгээ ашиглалтын зардалд 11,930.2 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 37,883.8 сая төгрөгийг тус тус зарцуулан, улсын төсөвт 3,100.0 сая төгрөгийг татан төвлөрүүлж, тусгай сангууд болон ОНЕО-ын харилцах дансны эцсийн үлдэгдэл 10,206.8 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Аймгийн ТЕЗ-ийн анхааралд толилуулах нь:

Аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд орлогыг 155,677.7 сая төгрөг, зарлагыг 153,358.5 сая төгрөг, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,646.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,965.4 сая төгрөгийг аудитаар баталгаажууллаа.

ДҮГНЭЛТ

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- МУ-ын 2024 оны Төсвийн тухай хуулиар аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг 76,112.3 сая төгрөгөөр баталж, нэмэлт өөрчлөлтөөр 9,462.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 85,575.1 сая төгрөгөөр тодотгож баталсныг аймаг, сумдын ИТХ-аас 61,949.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 147,524.9 сая төгрөгөөр баталсан байна.
- Сангийн яамнаас 2024 оны төсвийн орон нутгийн суурь зарлагыг 45,008.4 сая төгрөгөөр 2024 оны төсвийн тодотголоор суурь зарлагыг 46,329.0 сая төгрөгөөр баталсныг аймаг, сумдын ИТХ-аас 89,773.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 136,102.5 сая төгрөг болгож баталсан байна.
- Орон нутгийн 2024 оны орон нутгийн орлогын гүйцэтгэл 115,934.7 сая төгрөг буюу хэрэгжилт 78.6 хувь, зардлын гүйцэтгэл 109,944.6 сая төгрөг буюу хэрэгжилт 80.8 хувьтай байна.
- ААНОАТ-ын орлогоос аймагт 31,000.0 сая төгрөг төвлөрөхөөс 19,068.4 сая төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөөг 11,931.6 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь уул уурхайн компанийн улсын төсөвт төвлөрүүлэх орлого дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.
- Газрын дуудлага худалдааны орлого 30,000.0 сая төгрөг төвлөрөхөөс 4,215.5 сая төгрөг төвлөрүүлэн 25,789.4 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь аймаг, сумын хэмжээнд газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх асуудал газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хот хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнүүд хийгдээгүй нөхцөлд шийдвэрлэх боломжгүй болсон байна.
- Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого 8,673.8 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь орон нутгийн татварын болон татварын бус орлого 31,590.2 сая төгрөгөөр тасарсантай холбоотой байна.
- Сумдын орон нутгийн орлогоос аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 4,460.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.
- Аймгийн төсвөөс 7 суманд 2,314.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон байна.

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

АУДИТЫН МЕНЕЖЕР

У.ОЮУНТҮЛХҮҮР



АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

О.НАРАНГАРАВ

АУДИТОР

Г.МӨНХ-ОРГИЛ

Two handwritten signatures in black ink. The top signature is for O. Narangarav and the bottom signature is for G. Munkh-Orgil.

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.